

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ НЭГЖ

Гүйцэтгэлийн түвшин: I



1. Мэгжид Жанрайсэг бурхныг анх VIII Богд Жавзандамбын тохойн хэмжээгээр 80 тохой бүтээсэн нь 26м өндөртэй болжээ. Шүтээнийг 1200 лан алт, 1500 лан мөнгө, 4000 эрдэнийн чулуугаар чимжээ.

А. VIII Богдын тохойны урт хэдэн см байсан

.....

Б. Бурхныг бүтээхэд хэдэн грамм алт орсон бэ?

.....

В. 1 метр тутмыг хэдэн эрдэнийн чулуугаар чимсэн бэ?

.....

Гүйцэтгэлийн түвшин: II



2. Уламжлалт нэгжүүдийг шилжүүлж, бүхлээр тоймлон нөхөж бичээрэй.

	Ямх	Сөөм	Төө
1 дэлэм			
8 тохой			
2 төө			

3. Уртын нэгжүүдийг эрэмбэлж харгалзах дугаартай нь холбоорой.

1	20 алхам
2	47 төө
3	255 ямх
4	27 тохой

Гүйцэтгэлийн түвшин: III



4. 100 жин амуу тариаг Тэмүүлэн, Анужин, Энхжин гурав харгалзан 1:2:3 харьцаатай худалдав. Тэмүүлэн хэдэн килограмм амуу тариа зарж чадсан бэ?

Хариу :

5. Дүүрэн сүүтэй аяга 220 гр жинтэй. Сүүний гуравны хоёрыг уусны дараа 100 гр болсон байв. Хоосон аяганы жинг олж цэгийн оронд бичээрэй.

Хариу :

6. Гүйлтийн замаар Санчир, Сандуй хоёр гараанаас нэгэн зэрэг гарч уралдав. Барианд ороход Санчирт 24 метр үлдэхэд Сандуйд 48 метр үлдсэн байв. Санчир барианд ороход Сандуйд 30 метр үлдсэн бол гараанаас бариа хүртэл хэдэн метр вэ?

Хариу :

Гүйцэтгэлийн түвшин: IV



7. 30 дэлэм урттай усан бассейныг I хүн секундэд 3м хурдтай, II хүн секундэд 2м хурдтай туулна. Хэрэв тэд зэрэг сэлж эхэлсэн бол I нь бүх замыг туулаад эргээд хэдэн метр сэлээд II тамирчинтай уулзах вэ?

5 м

6 м

7 м

8. 4 нугас, 5 галуу нийлээд 4 кг 100 г жинтэй. Харин 5 нугас ба 4 галуу 4 кг жинтэй бол 1 нугас ямар жинтэй вэ?

400 г

450 г

500 г

9. Ижил зайд мэлхий, туулай хоёр уралдав. Туулай мэлхийнээс 35 дахин их хурдтай ба мэлхий зайг 2ц 20 минутад туулдаг ба тэд зэрэг барианд орохын тулд туулай мэлхийнээс хэчнээн хугацааны дараа гарах вэ?



2 цаг 14 мин

2 цаг 16 мин

2 цаг 1 мин



10. А хотоос ачааны машин, В хотоос автобус зэрэг угталцан гарч А хотоос 150 км зайд зөржээ. Ачааны машин бүх замыг 8.5 цаг, автобус 7.5 цаг туулдаг бол хоёр хотын хоорондох зайг ол.



.....



11. Малчин Жаргал нэг жил ажиллуулахаар туслах малчин хөлслөн авч 12 лан мөнгө, нэг дээл өгөхөөр тохиролцжээ. Гэтэл туслах малчин нь 7 сар ажиллаад явах болсон учир хөлсөнд нь 5 лан мөнгө, нэг дээл өгчээ. Дээл хэдэн лан мөнгөний үнэтэй вэ?

Хариу :

.....

12. Хүүхэд эцгээсээ өөрийн алхмаар 26 алхах зайд байв. Хүүхэд 4 алхах хугацаанд эцэг нь гурван алхам хийнэ. Хүүгийн гурван алхмын зайд эцэг нь 2 алхам хийдэг бол эцэг нь өөрийнхөө алхмаар хэдэн удаа алхаж хүүг гүйцэх вэ?

Хариу :

.....